



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 1/06

Мандалговь

Н.Дэлгэрмаагийн ажил хүлээлцэх ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, 83.2, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/243 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан аймгийн Засаг даргын Тамгын газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 3.7 дугаар хэсгийн 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого хариуцсан мэргэжилтнээр 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн Д.Цэвэлмаа томилогдон ажиллах болсон тул Н.Дэлгэрмаагийн ажлыг хүлээлгэн өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Болор-Эрдэнэ (Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Б.Солонго (Албан хэрэг хөтлөлтийн ажилтан)

Б.Хандмаа (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Баатардорж (Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав)

2. Ажил хүлээлцэх ажлыг зохих журмын дагуу 2023 оны 02 дугаар сарын сарын 15-ны өдрийн дотор зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

48 3150009